

ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 92-т “Шүгэл үлээгчийг хамгаалах тухай” хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Авлигатай тэмцэх газар хамтран боловсруулж, Засгийн газар өргөн барихаар заасан. Уг хуулийн төсөл боловсруулах үндэслэл, зохицуулах харилцааны товч утгыг “Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, мэдээлсэн, илчилсэн тохиолдолд яллах, эрүүгийн хариуцлагад татах, дарамтлахаас мэдээлэгчийг хамгаалах, шүгэл үлээгчдийг аливаа өш хонзон, гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгох” гэж тусгажээ.

Үүний дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай” хуулийн төсөл, түүний үзэл баримтлал, дагалдах хуулийн төслийг боловсруулан 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр цахим хуудастаа байршуулж олон нийтээс санал авч байна. Иймд энэхүү санал, шүүмжээр дамжуулан Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, зохицуулалт нь олон улсын гэрээ, конвенц, жишиг зарчмууд, сайн туршилагад нийцсэн эсэхэд дүгнэлт өгч, хуулийн төслийн чанар, агуулгыг сайжруулахад чиглэсэн тодорхой санал, зөвлөмжийг бодлого боловсруулагчдад хүргэхийг зорилоо.

Нэг. Авлигатай тэмцэх үйл ажиллагаа ба шүгэл үлээгчийн хамгаалалтын талаарх олон улсын стандарт, туршлага

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан Авлигын эсрэг конвенцыг Монгол Улс 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр соёрхон баталжээ.¹ Тус конвенцын 33 дугаар зүйлд мэдээлэгч этгээдийг хамгаалах талаар “Оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг ямарваа шударга бус хандлагаас хамгаалах тухай заах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэн оруулах асуудлыг авч үзнэ”² гэж зааснаас гадна

¹ Гадаад харилцааны яам, Монгол Улсын нэгдэж орсон олон талт олон улсын гэрээний жагсаалт

² Авлигын эсрэг НҮБ-ын конвенц, <https://www.legalinfo.mn/annex/details/6492?lawid=10269>

8 дугаар зүйлийн 4; 13 дугаар зүйлийн 2; 32 дугаар зүйлийн 1; 37 дугаар зүйлийн 4; 39 дүгээр зүйлийн 2-т мэдээлэгч этгээдийг хамгаалах нөхцөлийг тусгасан байна.³

Эдгээр зүйл, хэсгээс гадна Европын зөвлөлийн Авлигын эсрэг эрүүгийн эрх зүйн конвенц (1999), Авлигын эсрэг иргэний эрх зүйн конвенц (1999); Шүгэл үлээгчийг хамгаалах талаарх зөвлөмж (2014); Америкийн улсуудын холбоо (OAS)-ны Авлигын эсрэг Америкийн конвенц (1996); Африкийн холбооны Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх конвенц (2003); Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) Хахуулийн эсрэг конвенц; Олон улсын бизнесийн хэлцэлд хахуультай тэмцэх тухай зөвлөмж (2009); Төрийн албан дахь ёс зүйн дүрмийг сайжруулахтай холбоотой зөвлөмж (1998) зэрэг баримт бичгүүдэд мэдээлэгч этгээд буюу шүгэл үлээгчийг хамгаалахтай холбоотой олон улсын стандартыг тогтоож өгсөн гэж үздэг.

Эдгээр баримт бичигт авлигатай тэмцэх хүрээнд шүгэл үлээгчийг хамгаалахдаа хууль тогтоомжийн болон зохион байгуулалтын хувьд дараах асуудалд зайлшгүй анхаарах ёстой гэж үзжээ.⁴ Үүнд:

- Шүгэл үлээгчийг хэрхэн тодорхойлох;
- Ямар мэдээлэл өгөхөд шүгэл үлээгчийг хамгаалах;
- Шүгэл үлээгч нь хэнд мэдээлэх;
- Шүгэл үлээгчийг хэн, хэрхэн хамгаалах.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод мэдээлэгч этгээд буюу шүгэл үлээгчийг явцуу хүрээнд тодорхойлохоос зайлсхийж дараах этгээд шүгэл үлээгч байж болохоор зохицуулжээ. Үүнд:

- Төр, хувийн салбарт ажиллагч;
- Олон нийтийн төлөөлөл;
- Гэрч, хохирогч;
- Шинжээч.

Шүгэл үлээгчийг хамгаалах хуулийн зохицуулалттай холбоотой хэд хэдэн шалгуур бий.⁵

³ II. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ: Наймдугаар зүйл. Төрийн албан тушаалтны ёс зүйн дүрэм

4. Төрийн албан тушаалтан чиг үүргээ биелүүлэх явцад өөрт нь мэдэгдсэн авлигын үйлдлийн талаар эрх бүхий зохих байгууллагад мэдээлэх явдлыг хөнгөвчлөн дэмжих арга хэмжээ, тогтолцоог тогтоох асуудлыг оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авч үзнэ.

13 дугаар зүйл. Нийгмийн оролцоо

2. Оролцогч улс бүр энэхүү конвенцод заасан авлигын эсрэг тэмцэх холбогдох байгууллагын талаар олон нийт мэдэж байх явдлыг хангах талаар зохих арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийг бүрдүүлж байна гэж үзэж болох аливаа тохиолдлын талаар мэдээлэхээр эдгээр байгууллагад хандах боломж (үүнд нэрээ мэдүүлэхгүйгээр хандах боломж багтана)-оор хангана.

II бүлэг. Гэмт хэрэгт тооцох, хууль сахиулах: 32 дугаар зүйл. Гэрч, шинжээч, хохирогчийг хамгаалах

1. Оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн шаардлагатай тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс үр дүнтэйгээр хамгаалахаар заах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн, өөрийн боломжийн хэмжээнд авна.

37 дугаар зүйл. Хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах

4. Эдгээр этгээдийн хамгаалалтыг *mutatis mutandis* энэхүү конвенцын 32 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

39 дүгээр зүйл. Үндэсний эрх бүхий байгууллага, хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагаа

2. Оролцогч улс бүр өөрийн харьяат болон нутаг дэвсгэрт нь байнга оршин суугч бусад этгээдийн энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийг үйлдсэн талаар үндэсний мөрдөн байцаах ба яллах эрх бүхий байгууллагад мэдээлж байхыг хөхиүлэн дэмжих асуудлыг авч үзнэ.

⁴ United Nations Office on Drugs and Crime, The United Nations Convention against Corruption: Resource Guide on Good Practices in the Protection of Reporting Persons, New York, 2015. p. 8, https://www.unodc.org/documents/corruption/Publications/2015/15-04741_Person_Guide_eBook.pdf

⁵ United Nations Office on Drugs and Crime. The United Nations Convention against Corruption: Resource Guide on Good Practices in the Protection of Reporting Persons, New York, 2015. pp. 80-81, https://www.unodc.org/documents/corruption/Publications/2015/15-04741_Person_Guide_eBook.pdf

Эдгээрээс 2014 онд Европын зөвлөлийн гаргасан шүгэл үлээгчийг хамгаалах зохицуулалтыг үнэлэх шалгуурыг доорх хүснэгтэд танилцуулж байна.

ХҮСНЭГТ 1. ЕВРОПЫН ЗӨВЛӨЛӨӨС ГАРГАСАН ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙГ ХАМГААЛАХ ЗОХИЦУУЛАЛТЫГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

№	Шалгуур	Товч утга
1	Тодорхойлолт	“шүгэл үлээгч”, “мэдээлэх”, “нийтийн ашиг сонирхол”
2	Эрх зүйн зохицуулалтын хүрээ	Шүгэл үлээгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн зохицуулалтын хамрах хүрээ
3	Мэдээлэх, илчлэх суваг	Мэдээлэх, илчлэх сувгийн тодорхой байдал; дотоод суваг, дүрэм журам
4	Нууцлах	Мэдээлэгч этгээд нь нууцлагдах эрхтэй байх
5	Мэдээллийн мөрөөр авах арга хэмжээ	Мэдээллийг даруй мөрдөн шалгах; мэдээлэгч этгээдэд авсан арга хэмжээний талаар мэдэгдэж байх
6	Мэдээлэгч этгээдийг хамгаалах арга хэмжээ	Бүх төрлийн сөрөг үр дагавраас мэдээлэгч этгээдийг хамгаалах
7	Зөвлөгөө, ойлголт мэдлэг өгөх, үнэлгээ хийх	Зөвлөгөө өгсөн талаар нууцлах (зөвлөгөө өгсөн төлбөрөөс чөлөөлөх); үндэсний эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг үе шаттайгаар үнэлж байх

Энд харуулсан аль нэг шалгуурыг орхигдуулах, бүрэн бус тусгах тохиолдолд шүгэл үлээгчийн хамгаалалт доголдох, улмаар авлигатай тэмцэх үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Иймд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн албанаас шүгэл үлээгчийн хамгаалалтын талаарх олон улсын туршлагыг судалсны үндсэн дээр НҮБ-ын гишүүн орнуудад өгсөн дараах зөвлөмжийг Монгол Улсын хувьд харгалзан үзэж, эрх зүйн зохицуулалтдаа бүрэн тусгаж хэрэгжүүлэх нь зүйтэй.

А. Шүгэл үлээгчийг хамгаалах:

- Мэдээлэх нөхцөлийг хялбар байхаар хуульчлах, практикт хэрэгжүүлэхэд тодорхой байх;
- Мэдээлэх сувгийн олон талт, хүртээмжтэй байдлыг хангах;
- Хамгаалалтын арга хэмжээ нь мэдээлэгч этгээдийн нөхцөл байдал, шаардлагад нийцсэн байх;
- Хамгаалалтын арга хэмжээ нь эрх зүйн, процедурын, бүтцийн арга хэмжээнээс бүрдэх;
- Мэдээлэгч этгээдийг зөвлөгөө авах нөхцөлөөр хангах;
- Мэдээлэгч этгээдэд аюул занал, хохирол учрахаас сэргийлсэн арга хэмжээ авах, тийнхүү хохирсон нөхцөлд авах хариу арга хэмжээг тодорхой болгох;
- Мэдээлэх үйл ажиллагааг дэмжих (талархах, хүндэтгэл, шагнал урамшуулал олгох).

Б. Хэрэгжилтийг хангах:

- Эрх бүхий байгууллага мэдээлэл хүлээн авах, мэдээллийн мөрөөр мөрдөн шалгах, мэдээлэгч этгээдийг хамгаалах бүрэн эрх, чадамж, нөөцтэй байх;
- Эрх бүхий байгууллагын ажилтнууд мэдээллийн дагуу ажиллах, мэдээлэгч этгээдийг хамгаалахын тулд зохих сургалтад хамрагдсан байх, мэргэшсэн байх;
- Эрх бүхий байгууллага зохисгүй нөлөөнөөс ангид байх, чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх;
- Мэдээлэгч этгээдийг хамгаалах дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих, мониторинг хийх төв буюу хяналтын байгууллага байгуулах буюу ажиллуулах;

- Мэдээлэгч этгээдийг хамгаалах, олон нийтийн итгэлийг хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалт, бусад арга хэмжээний үр нөлөөг тогтмол шалгаж, үнэлэх.

Хоёр. Монгол Улсын хууль тогтоомжид шүгэл үлээгчийг хамгаалах асуудал тусгагдсан байдал

Монгол Улс НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Авлигын эсрэг конвенцыг 2005 оны 12 дугаар сард соёрхон баталсан хэдий ч энэхүү конвенцын 33 дугаар зүйлийн дагуу шүгэл үлээгчийг хамгаалах тухайлсан эрх зүйн орчин бүрдүүлэх үүргээ биелүүлээгүй 15 жил нэгэнт өнгөрчээ. Гэсэн хэдий ч шүгэл үлээгчийг хамгаалах талаар холбогдох бодлогын баримт бичигт тусгаж ирсэн байна.

Тодруулбал, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралт “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 5.2.5-д “...улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг шалгах, мэдээлэгчийг хамгаалахад иргэн хяналт тавих бололцоо бүрдсэн байх” гэж тусгаж, түүнийг уг хөтөлбөр хэрэгжүүлэх хоёр дахь үе шатад (2020-2023 он) хамааруулжээ.

Мөн Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт “Алсын хараа-2050: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 5.6.5-д “Авлига, албан тушаалын гэмт хэргийн мэдээлэл хүлээн авах, нууц хадгалах тогтолцоог бэхжүүлж, энэ төрлийн гэмт хэргийг илчилсэн, мэдээлсэн хүнийг хамгаалах эрх зүйн үндэс бүрдүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, олон нийтийн хяналтыг сайжруулна” гэж, Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 92-т Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Авлигатай тэмцэх газар хамтран боловсруулж, Засгийн газар өргөн барихаар заасан. Ингэхдээ хуулийн төслийг өргөн мэдүүлэх хугацааг “2023” гэж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах үндэслэл, зохицуулах харилцааны товч утгыг “Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, мэдээлсэн, илчилсэн тохиолдолд яллах, эрүүгийн хариуцлагад татах, дарамтлахаас мэдээлэгчийг хамгаалах, шүгэл үлээгчдийг аливаа өш хонзон, гэмт хэргийн хохирогч болохоос хамгаалах эрх зүйн зохицуулалт бий болгох” гэж тус тус тусгажээ.

Гэсэн хэдий ч дээрх бодлогын баримт бичгүүдэд шүгэл үлээгчийг хэрхэн хамгаалах асуудал тодорхой тусаагүй байна. Иймд авлигатай тэмцэх үйл ажиллагаа ба шүгэл үлээгчийн хамгаалалтын талаарх олон улсын стандарт, туршлагыг баримтлан Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн чанар, агуулгыг сайжруулахад чиглэсэн дараах санал, зөвлөмжийг танилцуулж байна.

Гурав. Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд өгөх санал, шүүмж

3.1. “Шүгэл үлээх” гэх ойлголтыг оновчтой тодорхойлох

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 4.1.1-д “шүгэл үлээх” гэж нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал, үйлдлийн талаар эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх, өргөдөл, гомдол гаргах, тайлбар өгөх (цаашид “мэдээлэл өгөх” гэх)-ийг ойлгоно” гэжээ. Энэхүү тодорхойлолтод эрх бүхий байгууллагад хандах нөхцөлийг тусгасан байна.

Транспаренси интернэшнл олон улсын байгууллагаас гаргасан “Шүгэл үлээгчийг хамгаалах хууль тогтоомжтой холбоотой олон улсын зарчим”-д “Шүгэл үлээх” гэдгийг төрийн болон хувийн секторын этгээдийн зүгээс нийтийн ашиг сонирхолд аюул, занал учруулахуйц авлига, хууль бус үйлдэл, залилан, аюултай үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тухайн мэдээллийн мөрөөр үр дүнтэй арга хэмжээ авна гэж итгэж буй хүн, хуулийн этгээдэд хандан илчлэх” гэж тодорхойлсон байна.⁶ Энэ тодорхойлолтын дагуу шүгэл үлээх гэдэгт шүгэл үлээгч нь заавал эрх бүхий байгууллагад хандах бус ажлын байрныхаа дотоодод, эрх бүхий байгууллагад, гуравдагч этгээд буюу хуульч, өмгөөлөгч, сэтгүүлчид хандах боломжтой байх бөгөөд “мэдээллийг илчлэх” үйлдлийг явцуу байдлаар тогтоохоос зайлсхийснийг харж болно.

Мөн “нийтийн ашиг сонирхолд аюул, занал учруулахуйц үйлдэл, үйл ажиллагаа” гэх ойлголт өргөн хүрээтэй байх нь зөв хэдий ч хэт тодорхой бус байх нь шүгэл үлээх эсэхэд эргэлзээ бий болгох үр дагавартай болохыг Европын Зөвлөлөөс онцолсон бөгөөд дээрх үйлдэл, үйл ажиллагаанд юу хамаарахыг олон нийтэд ойлгомжтой байдлаар тусгах нь зүйтэй гэжээ.⁷ Дээр дурдсан “Шүгэл үлээгчийг хамгаалах хууль тогтоомжтой холбоотой олон улсын зарчим”-д “нийтийн ашиг сонирхолд аюул, занал учруулсан буюу учруулахуйц хууль бус үйлдэл, үйл ажиллагаа”-г авлига, гэмт хэрэг, хууль ёсны үүргийг зөрчсөн үйлдэл, шударга ёсыг алдагдуулах (гэм зэмгүй хүнийг шийтгэх) үйлдэл, нийтийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул учруулах тодорхой үйлдэл, эрх мэдлээ урвуулан ашиглах үйлдэл, төсвийн хөрөнгийг хууль бусаар ашиглах, буруу менежмент, ашиг сонирхлын зөрчил болон эдгээр үйлдлийг нуун дарагдуулсан үйлдэл хамаарах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй гэж тодорхойлжээ.⁸

Санал: *Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 4.1.1-д заасан “шүгэл үлээх” гэх ойлголтыг дараах байдлаар өөрчлөн найруулах саналтай байна:*

“4.1.1. “Шүгэл үлээх” гэж авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, нийтийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул учруулах, эрх мэдлээ урвуулан ашиглах, төсвийн хөрөнгийг хууль бусаар ашиглах болон эдгээр үйлдлийг нуун дарагдуулах зэрэг нийтийн ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал, үйлдлийн талаар зохих арга хэмжээ авах хүн, хуулийн этгээдэд хандан тайлагнах, өргөдөл, гомдол гаргах, мэдээлэх, тайлбар өгөх зэргээр илчлэх (цаашид “мэдээлэл өгөх” гэх)-ийг” гэх.

3.2. Хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 3.2.2-г зааснаар “Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан төрийн нууцыг хамгаалах ажилтан, танилцах эрх бүхий этгээдийн танилцсан төрийн нууцад хамаарах мэдээлэл”-д энэ хууль үйлчлэхээргүй байна. Энэ заалт нь Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн зорилтыг алдагдуулах үр дагавартай болно. Тодруулбал, Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаар төрийн нууцад хамаарах

⁶ Transparency International. International Principles for Whistleblower Legislation, November 2013. <https://www.transparency.org/en/publications/international-principles-for-whistleblower-legislation>

⁷ Transparency International, A Best Practice Guide for Whistleblowing Legislation, March 2018, p. 8. <https://www.transparency.org/en/publications/best-practice-guide-for-whistleblowing-legislation>

⁸ Transparency International. International Principles for Whistleblower Legislation, 2013, p. 4%. <https://www.transparency.org/en/publications/international-principles-for-whistleblower-legislation>

мэдээллийн хүрээ маш өргөн, холбогдох мэдээллийг төрийн нууцад хамааруулахад хялбар, нууцлах шаардлагагүй мэдээллийг төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад нэмж оруулах эрсдэлтэй болсон.⁹

Нийт 33 байгууллага, салбарт хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээллийн тоо 60, Засгийн газрын тогтоолоор төрийн нууцад хамааруулсан мэдээллийн тоо 565 байна. Үүнээс төрийн нууцад хамааруулсан онц чухал зэрэглэлтэй мэдээллийн тоо 54, маш нууц зэрэглэлтэй мэдээллийн тоо 527 байна. Энэ нь 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд заасан төрийн нууцад хамаарах мэдээллийн тоо Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор хэд дахин нэмэгдсэн болохыг харуулж байна. Үүнээс гадна, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2-т зааснаар албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, тагнуулын байгууллагын саналыг авсны үндсэн дээр асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална. Үүнтэй холбоотойгоор албаны нууцын жагсаалтад хамаарах мэдээллийн тоо өнөөг хүртэл тодорхой бус байна.

Түүнчлэн, нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийн хөндөж буй мэдээллийг ихэвчлэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууцаар халхавчилсан байдаг тул “Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээхдээ ажилтай холбоотой нууц мэдээллийг агуулсан бол шүгэл үлээгчийг бусад хууль тогтоомж, хамтын гэрээ, хөдөлмөрийн дүрэм, журамд заасан ажил, мэргэжлийн хүрээнд нууц хадгалах үүргээ зөрчсөн гэж үзэхгүй” гэдэг зохицуулалт нь шүгэл үлээгчийг хамгаалахтай холбоотой стандарт заалт болдог.¹⁰ Энэ нь олон улсын зарчмуудад нэгэн адил тусгагдсан. Тодруулбал, “Үндэсний аюулгүй байдал ба мэдээлэл авах эрхийн талаарх олон улсын зарчим” буюу “Тшванийн зарчим”-д нийтийн ашиг сонирхлыг хамгаалах нь мэдээллийг нууцлах сонирхлоос илүү чухал байгаа тохиолдолд тийнхүү мэдээллийг нууцлах үүргээ зөрчсөн гэх төрийн албан хаагчийг шүгэл үлээгчтэй адилтган үзэж хамгаална гэж заасан.¹¹ Энэ зарчим нь Данийн Эрүүгийн хууль, Канадын Мэдээллийн аюулгүй байдлын тухай хуульд тус тус баталгаажсан байдаг.¹² Мөн Европын Зөвлөлөөс “шүгэл үлээгчийг хамгаалах хүрээг хязгаарлах нь хуулийн зохицуулалтад үл итгэх байдлыг нэмэгдүүлнэ” гэж онцолжээ.¹³

Мөн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 3.2.2-т заасан зохицуулалт нь Авлигын эсрэг хуулийн 8.2-т заасан “Энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар тогтоосон хязгаарлалт хамаарахгүй”, тус хуулийн төслийн 11.1-т заасан “...нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээхэд нууцын тухай хязгаарлалт хамаарахгүй” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

⁹ Глоб интернэшнл төв, Азийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, “Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ” сэдэвт судалгааны тайлан, “Олон улсын хэм хэмжээнд нийцсэн хуулиар дамжуулан олон нийтийн мэдээлэлтэй байх эрхийг дэмжих нь” төсөл, УБ., 2019, 15-19 дэх тал. https://www.gic.mn/public/docs/publications/public_Restrictions_right_to_information_acts_pdf_2019.pdf

¹⁰ БНСУ-ын Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль, 14.3.

¹¹ Global Principles on National Security and the Right to Information (The Tshwane Principles). <http://www.right2info.org/exceptions-to-access/national-security/global-principles>

¹² Criminal Code (Denmark), section 152(e) (2010), The Security of Information Act of Canada (1985).

¹³ Council of Europe, Protection of Whistleblowers: A Brief Guide for Implementing a National Framework (2015), p. 8. <https://edoc.coe.int/en/fundamental-freedoms/7053-protection-of-whistleblowers-a-brief-guide-for-implementing-a-national-framework.html>

Санал: *Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 3.2.2-т “Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан төрийн нууцыг хамгаалах ажилтан, танилцах эрх бүхий этгээдийн танилцсан төрийн нууцад хамаарах мэдээлэл” гэж заасныг хасах.*

Хуулийн төслийн 2.1-д “Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Авлигын эсрэг болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулиуд болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэжээ. Харин тус хуулийн төсөл бусад хуультай хэрхэн уялдах асуудлыг тодорхойгүй үлдээсэн байна.

Санал: *Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлд “Энэхүү хууль нь бусад хуульд заасан шүгэл үлээгчийг хамгаалах зохицуулалттай нийцэж буй бол энэхүү хуулийг хэрэглэнэ. Хэрэв бусад хуульд шүгэл үлээгчтэй холбоотой илүү таатай нөхцөлийг тусгасан бол тэдгээр хуулийг хэрэглэнэ” гэсэн хэсэг нэмэх.*

3.3. Шүгэл үлээх арга зам, сувгийг оновчтой болгох

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 3.2, 7.1, 7.2 дахь хэсэгт буй зохицуулалтаас харахад зөвхөн төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэлтэй холбоотойгоор төрийн байгууллагад хандаж шүгэл үлээх боломжтой байна. Шүгэл үлээх үндсэн зорилго нь хууль бус үйлдлийг зогсоох, тэрхүү хууль бус үйлдэлд арга хэмжээ авах юм. Тиймээс тэрхүү хууль бус үйлдэл гарч буй газарт хандаж мэдээллийг илчлэх нь чухал бөгөөд шүгэл үлээх буюу мэдээллийг илчлэх механизм нь уян хатан буюу итгэл хүлээхүйц байх шаардлагатай.


Энэ шалтгаанаар хууль бус үйлдлийг мэдээлэх үндсэн гурван арга зам байх нь зүйтэй гэж Европын Зөвлөлөөс зөвлөмж болгожээ.¹⁴ Үүнд, ажлын байрандаа буюу дотооддоо мэдээлэх, эрх бүхий байгууллагад мэдээлэх, гадагшаа буюу олон нийтэд мэдээлэх арга зам хамаарна. Эдгээр арга зам нь шүгэл үлээгчийг хамгаалах, тийнхүү шүгэл үлээх найдвартай сувгаар хангах, холбогдох тусгайлсан журамтай байх шаардлагыг нэгэн адил агуулна.

Европын Холбооноос “Европын Холбооны эрх зүйг зөрчсөн асуудлаар мэдээлсэн этгээдийг хамгаалах тухай” (Шүгэл үлээгчийг хамгаалах) удирдамжийг 2019 онд баталж, түүний гишүүн 27 улсыг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр хүртэлх хугацаанд дотоодын хууль тогтоомжоо тус удирдамжид нийцүүлэх үүрэг хүлээлгэсэн.¹⁵ Европын Холбооны энэхүү удирдамжид зааснаар 50-иас дээш ажилтантай байгууллагуудын хувьд дотооддоо мэдээлэх суваг бий болгох үүрэг хүлээлгэж, тэрхүү мэдээллийг хүлээн авсан компани, олон нийтийн байгууллага, эрх бүхий


¹⁴ Council of Europe, 2014, Principle 14.

¹⁵ Directive (EU), 2019/1937 of the European Parliament and of the Council of 23 October 2019 on the protection of persons who report breaches of Union law (Whistleblower Protection Directive).
<https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A32019L1937>

байгууллага түүний мөрөөр арга хэмжээ авахыг үүрэг болгосон. Мөн шүгэл үлээгч гэдэгт зөвхөн ажилтан гэлтгүй тухайн ажилтай холбоотой хууль бус үйлдлийг мэдсэн этгээд байх боломжтой.¹⁶



Санал: Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 3.3-т “Тавиас дээш ажилтантай аж ахуйн нэгж дотооддоо түүний ажилтан буюу ажил, үүргийн хүрээнд хамтран ажиллах этгээд шүгэл үлээх суваг бий болгох бөгөөд түүний мөрөөр арга хэмжээ авах, энэ хуульд заасны дагуу шүгэл үлээгчийг хамгаалах баталгааг бүрдүүлнэ” гэж нэмэх.



Дээр дурдсаны дагуу ажлын байрандаа шүгэл үлээх нь боломжгүй буюу үр нөлөөгүй бол тухайн хувь хүний хувьд зохицуулах болон хяналт тавих байгууллага буюу тухайн байгууллагын гаднах этгээдэд хандаж шүгэл үлээж болно. Ийнхүү шүгэл үлээх суваг нь төрийн эрх бүхий байгууллага, хууль сахиулах, мөрдөн шалгах байгууллага, сонгогдсон албан тушаалтан, тухайн мэдээллийг хүлээн авахаар байгуулагдсан тусгайлсан байгууллага, хуульч, сэтгүүлч байна.¹⁷ Тухайлбал, Австрали Улсад шүгэл үлээгч мөрдөн шалгуулахгүй байх, тийнхүү мөрдөн шалгуулсан ч ямар нэг арга хэмжээ авах

¹⁶ Transparency International, “Are EU Governments Taking Whistleblower Protection Seriously?”, Progress report on transposition of the EU Directive, p. 5, 24 March 2021. <https://www.transparency.org/en/publications/eu-governments-whistleblower-protection>

¹⁷ Transparency International, International Principles for Whistleblower Legislation, p. 7, November 2013. <https://www.transparency.org/en/publications/international-principles-for-whistleblower-legislation>

нь тодорхойгүй буюу зургаан сарын хугацаа өнгөрсөн ч шүгэл үлээгчид арга хэмжээ авсан эсэх талаар мэдэгдээгүй бол шүгэл үлээгч сэтгүүлчдэд хандаж болохоор хуульчилсан байна.¹⁸

Санал: *Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлд дараах хэсгийг нэмэх саналтай байна:*

“6.8. Энэ хуулийн 6.1-д зааснаас үл хамааран шүгэл үлээгч нь өөрийн хувийн мэдээллийг ил болгохгүйгээр өөрийн өмнөөс хуульчаар, эсхүл сэтгүүлчээр дамжуулан шүгэл үлээж болно.

6.9. Энэ хуулийн 6.8-д заасан тохиолдолд энэ хуулийн 6.2.3-т заасан шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг хуульчийн эсхүл сэтгүүлчийн мэдээллээр орлуулна.

6.10. Энэ хуулийн 6.8, 6.9-д заасан хуульч, сэтгүүлчээс шүгэл үлээгчийн үйл ажиллагаатай нь холбогдуулан гэрчээр болон бусад байдлаар байцаах, нөхцөл байдлыг тодруулах зорилгоор мэдүүлэг, тайлбар авах, шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг шаардахыг хориглоно”.

Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 7.1-д “Шүгэл үлээгч энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийг эрх бүхий байгууллага эсхүл Мэдээллийн шуурхай удирдлагын төвд хүргүүлнэ” гэж, 7.2-т “Эрх бүхий байгууллага нь Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Цагдаагийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар байна” гэж зааснаас харахад шүгэл үлээгчийг хамгаалах асуудал эрхэлсэн тусгайлсан байгууллага аль нь болох нь тодорхойгүй, тэдгээр эрх бүхий байгууллага бүгд адил эрх хэмжээтэй байх эсэх, шүгэл үлээхтэй холбоотой ямар үе шатанд аль байгууллага оролцох нь тодорхойгүй байна.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын 33 дугаар зүйлд заасан шүгэл үлээгчээс мэдээлэл хүлээн авах “эрх бүхий байгууллага” гэдэгт авлигатай тэмцэх бие даасан байгууллага, омбудсман, аудитын байгууллага, цагдааг ойлгоно. Хэрэв эдгээр эрх бүхий байгууллага нь үр дүнтэй хууль сахиулах эрх мэдэлтэй бөгөөд асуудлыг шуурхай, няхуур шийдвэрлэвэл шүгэл үлээгчээс “өшөө авах” бололцоо олгохгүй. Шүгэл үлээгчийг хамгаалах нь шүүхийн нэг чиг үүрэг хэдий ч шүүхийн үйл ажиллагаа удаан, зардалтай байдаг тул тусгайлсан байгууллага шүгэл үлээгчийг хамгаалах чиг үүрэгтэй байх нь оновчтой. БНСУ-д шүгэл үлээгчийн хандах байгууллага нь авлигын эсрэг комисс болон омбудсманы чиг үүргийг нэгтгэсэн Авлигын эсрэг, иргэний эрхийн комисс гэх шинэ байгууллага юм. Энэ нь шүгэл үлээгчийг хамгаалах эрх мэдэлтэй бөгөөд үр нөлөөтэй тогтолцоонд тооцогдож, Азийн улсуудын сайн жишээ болж байна.¹⁹ Авлигын эсрэг, иргэний эрхийн комисс нь асуудлыг өөрөө мөрдөн шалгахгүй, гэхдээ хэргийг бусад байгууллагад шилжүүлэх бөгөөд тухайн хэргийн талаарх хяналтаа хадгалж үлддэг нь чухал юм. Төвчхон өгүүлбэл, шүгэл үлээгчийг хамгаалах асуудлыг дагнан хариуцаж, бусад байгууллагатай уялдаа холбоотой ажиллах байгууллага ажиллах нь шүгэл үлээгчийг үр дүнтэй хамгаалахад зайлшгүй шаардлагатай байна.

¹⁸ Queensland Public interest Disclosure Act of 2010, part 4.

¹⁹ Transparency International. Whistleblower Protection and the UN Convention Against Corruption, 2013, pp. 7, 13, 16. <https://www.transparency.org/en/publications/whistleblower-protection-and-the-un-convention-against-corruption>

Санал: Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 7 дугаар зүйлд дараах нэмэлт оруулах саналтай байна:

“Авлигатай тэмцэх газар шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалахтай холбоотой дараах асуудлаарх бодлогыг тодорхойлох, уялдуулан зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1. Шүгэл үлээсэн тохиолдлыг бүртгэх, түүний мөрөөр арга хэмжээ авах;
2. Шүгэл үлээгчийн нууцлал, хувийн аюулгүй байдлыг хангах;
3. Шүгэл үлээгчийн болон тэдгээрийн хамгаалалтын эсрэг сөрөг арга хэмжээ авахыг хориглох;
4. Шүгэл үлээгчийг урамшуулах, тэдгээрт хөнгөлөлт үзүүлэх;
5. Шүгэл үлээгчийг хамгаалах арга хэмжээ авахад чиглэсэн боловсрол олгох, сурталчилгаа явуулах.”

“Хүн, хуулийн этгээд нийтийн ашиг сонирхлыг хохироосон буюу тийнхүү хохироох гэж буй талаар Авлигатай тэмцэх газарт эсхүл дараах этгээдэд хандан мэдээлж болно:

1. Нийтийн ашиг сонирхлыг хохироосон буюу хохироож болзошгүй институт, байгууллага, компанийн төлөөлөгч буюу ажил олгогч этгээд;
2. Нийтийн ашиг сонирхлын хохиролтой холбоотой асуудлыг удирдан чиглүүлэх, хянах, зохицуулах, шалгах эрх бүхий захиргааны байгууллага буюу хяналтын байгууллага;
3. Мөрдөн шалгах байгууллага;
4. Прокурорын байгууллага.”

“Хүний эрхийн Үндэсний Комисс нь Авлигатай тэмцэх газартай хамтран шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах, шүгэл үлээгчийн өгсөн мэдээллийг шалгаж, шийдвэрлэж буй үйл явцад хөндлөнгийн хяналт тавина”.

3.4. Шүгэл үлээгчийг хамгаалах нөхцөлийг сайжруулах

Хуулийн төслийн 15.1-д “Эрх бүхий байгууллага нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн мэдээлэл хүлээн авсан, бүртгэсэн, шилжүүлсэн, хянан шалгасан, шүгэл үлээгчид хамгаалалтын арга хэмжээ авсан, цуцалсан, хохирлыг барагдуулсан, урамшуулал олгосон тухай мэдээллийг агуулсан дундын мэдээллийн сантай байна”, 15.2-т “Дундын мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах, аюулгүй байдлыг хангах журмыг эрх бүхий байгууллага хамтран батална” гэж заасан байх бөгөөд тэрхүү мэдээллийн сангийн мэдээлэл ил болсноор шүгэл үлээгчийн аюулгүй байдал алдагдах эрсдэлтэй байх тул тус мэдээллийн санг нууцлах шаардлагатай. Хууль тогтоомжийн тухай хуулийн 16.3-т зааснаар хууль тогтоомжийн төсөл боловсруулахдаа тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслийг хамт боловсруулсан байх ёстой.

Санал: Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг дагалдуулан Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д “Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуульд заасан шүгэл үлээгчид хамгаалалтын арга хэмжээ авах журам, арга хэмжээний явц, уг арга хэмжээгээр хамгаалагдсан этгээдийн нууцлалбал зохих мэдээлэл” гэж нэмэх.

3.5. Шүгэл үлээсэн мэдээллийн мөрөөр авах арга хэмжээг тодорхой болгох

Хуулийн төслийн 7 ба 8 дугаар зүйлийн холбогдох хэсэгт шүгэл үлээсэн мэдээллийн мөрөөр авах арга хэмжээтэй холбоотой харилцааг тусгажээ. Эндээс харахад шүгэл үлээж, өгсөн мэдээллийн мөрөөр авах арга хэмжээ нь мэдээлэл хүлээн авсан байгууллагын харьяалан шийдвэрлэх асуудал эсэхээс хамаарах, хяналт шалгалт явуулах, түүний үр дүнг шүгэл үлээгчид мэдэгдэхээр хязгаарлагдаж байна.

Транспаренси интернэшнл олон улсын байгууллагаас гаргасан “Шүгэл үлээгчийг хамгаалах хууль тогтоомжтой холбоотой олон улсын зарчим”-ын 30-д зааснаар шүгэл үлээж, өгсөн мэдээллийн мөрөөр зохих байгууллага үргэлжлүүлэн ажиллах, залруулах арга хэмжээ авах, бодлогын шинэтгэл хийх нь гол үр дүн байх юм. Тодруулбал, шүгэл үлээж буй зорилго нь нийтийн эрх ашгийг хангах бодлогын өөрчлөлт гаргах бөгөөд хяналт шалгалтын талаар шүгэл үлээгчид мэдээлэл өгөхөөр хязгаарлагдах ёсгүй.

Санал: Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 7, 8 дугаар зүйлд дараах агуулгыг тусгах. Үүнд:

“Авлигатай тэмцэх газар (АТГ), эрх бүхий байгууллага хэргийг хүлээн авснаас хойш шүгэл үлээгчийн хувийн мэдээлэл, шүгэл үлээж буй зорилго зэрэг тухайн хэрэгт тусгайлан шаардлагатай мэдээллийг баталгаажуулж болно. АТГ энд дурдсан мэдээллийн үнэн эсэхийг шалгах үед шаардлагатай нэмэлт материал ирүүлэхийг хүсэж болно.

АТГ мэдээллийг баталгаажуулж дууссаны дараа шүгэл үлээж буй хэргийг холбогдох хяналтын байгууллага буюу мөрдөн шалгах байгууллагад даруй шилжүүлж, энэ тухай шүгэл үлээгчид мэдэгдэнэ.

Шүгэл үлээж буй хэргийг шилжүүлэн авсан хяналтын байгууллага буюу мөрдөн шалгах байгууллага нь тийнхүү хянан, мөрдөн шалгаж дууссаны дараа үр дүнг АТГ-т мэдэгдэнэ. АТГ хяналт шалгалт, мөрдөн байцаалтын үр дүнгийн талаарх хураангуйг шүгэл үлээгчид мэдээлнэ.

АТГ мөрдөн шалгалтын үр дүнгийн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараа нийтийн ашиг сонирхлыг хохироох үйлдэл нэмэгдэх, давтагдахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль, дүрэмд заасны дагуу дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаарх дүгнэлт, зөвлөмжөө мөрдөн байцаах байгууллагын хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийн хамт холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж болно:

- 1. Бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдахыг түдгэлзүүлэх буюу бүтээгдэхүүнийг буцаан татах, устгах;*
- 2. Ажил, үйлчилгээ болон мэргэшлийн үйл ажиллагааг түдгэлзүүлэх;*
- 3. Нийтийн ашиг сонирхлыг хохироосон зөрчлийг арилгах буюу урьдчилан сэргийлэхтэй холбоотой бусад шаардлагатай арга хэмжээ авах;*

Мэдэгдэл хүлээн авсан шүгэл үлээгч хяналт шалгалт буюу мөрдөн байцаалтын үр дүнгийн талаарх гомдлоо АТГ-т гаргаж болно.

АТГ-аас хяналтын байгууллагын хийсэн хяналт шалгалт буюу мөрдөн байцаах байгууллагаас хийсэн мөрдөн шалгалтыг хангалтгүй гэж үзсэн буюу шүгэл үлээгчийн гаргасан гомдол үндэслэлтэй гэж үзвэл хяналтын байгууллагыг дахин хянах буюу мөрдөн шалгах байгууллагыг дахин мөрдөн байцаалт явуулах талаар хүсэлт гаргаж болно.

Хяналтын байгууллага, мөрдөн шалгах байгууллага дахин хянан, мөрдөн шалгасны дараа тэрхүү үр дүнг АТГ-т мэдэгдэнэ.

АТГ-аас дүгнэлт, зөвлөмж хүлээн авсан холбогдох байгууллага, албан тушаалтан түүний мөрөөр хэрэгжүүлсэн ажил, үр дүнгийн талаараа олон нийтэд тухай бүр мэдээлж байна”.

3.6. Хуулийн төслийг сайжруулах бусад санал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 28.4.4-т хуулийн нэр нь агуулгыг товч, тодорхой илэрхийлсэн байх талаар заасан. Хуулийн төсөл шүгэл үлээгч хэн байхаас илүүтэй илчилж буй мэдээллийн баримт, үндэслэлтэй байх шаардлагад түлхүү анхаарах нь чухал юм. “Шүгэл үлээх тухай” “Шүгэл үлээх эрхийг баталгаажуулах тухай”, “Шүгэл үлээгчийг хамгаалах тухай” гэж хуулийн төслийг нэрлэх нь шүгэл үлээгчийн эрх зүйн байдал гэж субъектэд ач холбогдол өгөхөөс илүүтэй нийтийн эрх ашиг зөрчсөн, зөрчигдөж болзошгүй нөхцөл байдлыг илчлэх баримт, нотолгоо бүхий мэдээллийг илчлэх үйл ажиллагаанд түлхүү анхаарсан агуулгатай болох боломжтой. Хуулийн төслийн зорилтыг “нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээх нөхцөлийг бүрдүүлэх, шүгэл үлээгчийг дэмжих, хамгаалах, урамшуулах, түүний эрх зүйн байдлыг дордуулсан шинжтэй аливаа үйлдлээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах” гэж тодорхойлноос харахад ч энэ хуулийн төсөл нь зөвхөн шүгэл үлээгчийн эрх зүйн байдлаар хязгаарлагдахгүй юм.

Санал: *Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн нэрийг “Шүгэл үлээгчийг хамгаалах тухай” гэж өөрчлөх.*

Хуулийн төслийн 9.5-д “Шүгэл үлээгч нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээхээс өмнө болон шүгэл үлээсний дараа энэ хуулийн 6.1.6-д заасан хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө авч болно” гэж заасан байх боловч 6.1.6 гэсэн заалт тус төсөлд байхгүй. Харин хуулийн төслийн 14.1-т “Эрх бүхий байгууллага нь шүгэл үлээгчийг дэмжихтэй холбоотой дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж, 14.1.6-д “шүгэл үлээгчид хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах” гэж заасан байна.

Санал: *Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн 9.5 дахь хэсгийг “Шүгэл үлээгч нь нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээхээс өмнө болон үлээсний дараа энэ хуулийн 14.1.6-д заасан хууль зүйн болон сэтгэл зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө авч болно” гэж өөрчлөн найруулах.*

“Хуулийн шүүмж”-ийн энэ удаагийн дугаарыг авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн гишүүдийн санал, шүүмжид үндэслэн судлаач Л.Галбаатар, ННФ-ын эрх зүйн хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаа нар боловсруулав.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамъян гүний гудамж-5/1
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар-14240
Монгол Улс
Утас: (976) 76113207
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn